



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 32

Номгон

**“Мазаалай-баавгай, “12-жил” хүүхдийн
буддаг ном төсөл”-ийг дэмжих тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дэлхийд ховордсон мазаалай баавгайг хайрлан хамгаалж, олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор хэрэгжүүлж байгаа “Мазаалай-баавгай, “12-жил” хүүхдийн буддаг ном төсөл”-ийг дэмжсүгэй.

2. Монгол орны болон орон нутгийн нэн ховор амьтад, соёлын биет болон биет бус өвийг хамгаалан сурталчилж байгаа “Мазаалай-баавгай, “12-жил” хүүхдийн буддаг ном төсөл”-ийг дэмжиж, аймаг, сумдын цэцэрлэг, сургуулиудад хандан уриалга гаргаж, хамтран ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР